



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 01 сарын 17 өдөр

Дугаар А28

Мөрөн

Ногоон тэжээл, хивэгний үнэ хямдруулан
олгох тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2017 оны 78 дугаар тогтоол, аймгийн Онцгой комиссын 2018 оны анхдугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Мал хамгаалах сангийн аюулгүйн нөөцөд байгаа 100 тн хивэг, 400 тн ногоон тэжээлийг 50 хувь хямдруулж, худалдан борлуулахыг Хүнс, Хөдөө аж ахуйн газрын дарга /Г.Баттулга/-д зөвшөөрсүгэй.

2. 100 тн хивгийг 1 шуудайг нь 8000 /Найман мянга /төгрөгөөр, 400 тн ногоон тэжээлийг 1 боодлыг нь 4500 /Дөрвөн мянга таван зуу/-н төгрөгөөр хямдруулсан үнээр сумдаас захиалга авч мөнгө бүрэн төвлөрүүлсэн тохиолдолд олгохыг Мал хамгаалах сангийн нягтлан бодогч /Я.Баянжаргал/, нярав /С.Отгонбат/ нарт даалгасугай.

3. Энэхүү захирамжийн биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн ЗДТГ-ын Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Э.Аззаяа/, Хүнс, Хөдөө аж ахуйн газрын дарга /Г.Баттулга/ нарт үүрэг болгосугай.

ДАРГА



Л.ГАНБОЛД

01110040